

ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО ТҮҮНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦООГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

*ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн Захирал
Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), Профессор Ж.Баясах
Email: bayasakhjk@gmail.com*

Өнөөгийн Олон Улсын Харилцааны Хүрээлэн нь Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн харьяа хүрээлэн бөгөөд 1968 онд байгуулагдсан. Өдгөө тус хүрээлэн нь 39 ажилтантай, үүнээс 60 хувь нь боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэгтэй эрдэмтэд ажиллаж байна. Анх байгуулагдсан цагаас хойш Хятад судлал болон хөрш орон судлалын чиглэлээр онцгой анхааран ажиллаж байна. Мөн Монгол Улсын гадаад бодлогын асуудлаар дагнан судалгаа хийж ирсэн улсын эрдэм шинжилгээний байгууллага юм. Өнөөдөр хөрш орон судлал, гуравдагч хөрш орон судлал, олон улсын харилцаа, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа, бүс нутаг судлал олон улсын байгууллага гэсэн таван салбартайгаар судалгааны чиглэлээр ажиллаж байна.

Миний бие 2015 оны 2-дугаар сарын 15-наас тус хүрээлэнгийн захирлын албыг хашиж байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын сонин хэвлэл, радио телевизээр байнга Монгол Улсын гадаад бодлогыг тайлбарлан таниулдаг бөгөөд дэлхийд болж буй үйл явдлын талаар Монгол Улсын байр суурийг илэрхийлэн таниулж ирсэн. Өнгөрсөн жил 49 удаа сонин хэвлэл, телевизид ярилцлага өгсөн байна. Өнгөрсөн

гурван жилд 160 удаа олон улсын байдал хийгээд өрнөж буй үйл явдлын талаар өөрсдийн тайлбарыг өгсөн болно.

Олон Улсын Харилцааны Хүрээлэн суурь болон хавсарга судалгааны төслүүдийг авч хэрэгжүүлдэг. Монгол Улсын БСШУЯ-ны дэргэдэх Шинжлэх Ухаан Технологийн Сангаас санхүүжүүлсэн суурь судалгааны хоёр сэдэвт ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд энэ хүрээнд хөрш орон, стратегийн түншлэлийн салбараас 2017-2019 онуудад “Хүйтэн дайнаас хойшхи Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа” сэдэвт суурь судалгааны төслийг авч хэрэгжүүлж байна. Бүс нутаг олон улсын байгууллагын салбараас 2017-2019 онуудад “Азийн бүс нутгийн үйл ажиллагаа дахь Монгол Улсын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж” гэсэн сэдэвт суурь судалгааны ажлыг хийж байна. Монгол Улсын хөгжилд гадаад хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэдэг ба Монгол Улсын гадаад орчинд болж буй өөрчлөлтүүдийг ажиглан, нарийн нэгдсэн судалгаа явуулж, хөгжлийнхөө чиг хандлагыг тэдгээртэй уялдуулах нь өнөөгийн чухал асуудлын нэг болоод байна. Хүйтэн дайн дуусгавар болж Монгол Улс геополитикийн шинэ орчинд орсноор хоёр хөрштэйгөө харилцах харилцаа шинээр тодорхойлогдох болов. Эдгээр суурь судалгааны ажлын гол зорилго нь Орос, Хятад гэсэн хүчирхэг хоёр том гүрний дунд оршдог далайд гарцаагүй орны хувьд Монгол Улс нь олон улсын зах зээлд нэвтрэх, улс орнуудтай харилцахад хоёр хөрш оронтойгоо хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай юм. Тиймээс Монгол, Орос, Хятадын гурамсан харилцааг судлахын тулд гурван улсын геополитик, гео-эдийн засаг, гео-стратегийн асуудлыг олон улсын харилцааны онолын үүднээс авч үзэх шаардлагатай байна. Гурван талт хамтын ажиллагааны хөгжил, дамжин өнгөрөх тээвэр, гурван улсын нөөцийг хамтран ашиглах, уул уурхай, эрчим хүч, банк санхүү, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хил орчмын бүсийн хөгжлийн асуудал, байгаль экологи, хүмүүнлэгийн солилцоо, аялал жуулчлал зэрэг асуудлыг гурван талын хамтын ажиллагааны хүрээнд судлах, талуудын харилцан сонирхол, нийцэл юунд оршиж, төвлөрч буйг судлах шаардлага тулгарч байна. Суурь судалгааны үр дүнд бид хичнээн хурал, ямар ном бүтээл хэвлүүлэх зэрэг төлөвлөгөө гарган ажилладаг. Дээрхи хоёр сэдэв бол Монгол Улсын гадаад бодлого,

ялангуяа хөрш хоёр оронтой ямар харилцаатай байх талаар судлан тодорхойлох зорилготой.

Монгол Улс нь 1994 оны 6-р сарын 30-нд гадаад харилцааны үндсэн баримт бичиг болох “гадаад бодлогын үзэл баримтлал” батлагдан гарсан билээ. Сүүлийн гадаад бодлогын үзэл баримтлалыг 2011 онд гаргасан. Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд хоёр хөрш оронтой тэнцвэртэй харилцана гэж заасан байдаг. Мөн Монгол Улсын гуравдагч хөрш орнуудтай олон тулгуурт бодлогоор сайн харилцаатай, хамтран ажиллана гэж заасан байдаг. Үүнийг удирдлага болгон гадаад орнуудад болж буй үйл явдалд Монгол Улс өөрийн байр сууринаас тайлбарладаг. Жишээ нь: Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад /ШХАБ/ Монгол Улс 2006 оноос ажиглагчийн статустай оролцдог болсон. Энэ оны (2018 оны 6 сард) Циндаод ШХАБ-ийн дээд хэмжээний уулзалт болно. Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч оролцоно. Энэ байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улс хэрхэн оролцох талаар өөрийн байр сууринаас хандана. Манай хүрээлэнгийн судлаачид болон бид ажиглагчийн байр сууринаас хандана. Учир нь ШХАБ нь 2000 онд байгуулагдсан бөгөөд “терроризм, экстремизм, сепаратизм” гэсэн гурван гамшигтай тэмцэх нь ШХАБ-ын өнгөрсөн хугацаанд дахь зорилго, зорилтууд болж ирсэн.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд ОХУ, БНХАУ гэсэн хоёр хөрш орон дээр нь” гуравдагч хөрш” гэсэн Монгол Улсын гадаад бодлогын “тулгын гурван чулуу” гэж үзэн тайлбарлан, судалгаа хийдэг. Нэгдүгээрт: ШХАБ-д Монгол Улс элсэж болохгүй зүйл нь тус байгууллагын дүрэмд “ШХАБ гишүүн орнууд өөр хоорондоо харилцах харилцааг нэгдүгээрт тавина” бусад улсуудтай харилцах харилцааг хоёрдугаарт тавина гэж заасан нь манай улсын олон тулгуурт гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж байна. Мөн манай улс гуравдагч хөрш орнууд болох АНУ, Япон, ХБНГУ, Өмнөд Солонгос, Их Британи, Швед, Швейцарь гэх мэт олон орнуудтай сайн харилцаатай. Өөрөөр хэлбэл манай улсын хувьд ШХАБ-ын гишүүнчлэлд яаран орох хэрэггүй. Хоёрдугаарт: Манай хоёр хөрш орон Монгол Улсыг ШХАБ-ын жинхэнэ гишүүн орон болохыг байнга шахаж байгаа боловч бид гадаад бодлогын олон тулгуурт үзэл баримтлалын хүрээнд яаран тус байгууллагад гишүүнээр элсэхгүй.

2014 оны 3-дугаар сард Украины хямрал гарсанаас хойш ОХУ, Украин хоёр улсын асуудал хурцадсан. Бид эхнээс нь ОХУ-ын байр суурийг зөв гэж үзсэн. Тийм учраас бид сонин хэвлэлд энэ талаар бичихдээ Өрнөдийн сонин хэвлэлийг дагахгүйгээр ОХУ-ын хэвлэл мэдээллийг гол болгон төвийг сахих үүднээс Орос Украины асуудлыг тайлбарлахыг эрхэмлэдэг. Мөн хэт ОХУ-ын талыг барихгүй, хэт Өрнөдийн хэвлэлийн талыг барихгүйгээр төвийг сахих байр суурийг урьтал болгон дээрхи хямралын асуудлыг тайлбарлаж байна. Украины хямралаас үүдэн ОХУ болон БНХАУ-ын харилцаа улам бүр ойртсон. Мөн БНХАУ-ын дарга Си Зиньпин 2013 онд “Шинэ торгоны зам” төсөл өдгөө “Нэг бүс, нэг зам” төсөл хэрэгжүүлэх болсоноор Монгол Улс, ОХУ, БНХАУ гурван улсын харилцаа шинэ түвшинд хөгжиж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржийн санаачилгаар гурван улсын Ерөнхийлөгч нар Тажикстаны нийслэл Душанбе, Узбекистаны нийслэл Ташкент, Оросын Уфа зэрэг хотуудад Хятад, Орос, Монгол улсын дээд хэмжээний уулзалт болсон. Узбекистаны нийслэл Ташкент хотод болсон уулзалтаар “гурван улсын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөр батлагдаж, Монгол Улс 34 төсөлд оролцохоор болсон. Мөн Монгол Улс “Төвийг сахих” бодлого баримтлахаар болсон боловч түрүүчийн УИХ-аар батлуулж чадсангүй.

Монгол Улс 1993 онд ОХУ-тай, мөн 1994 онд БНХАУ-тай “Найрамдлын хамтын ажиллагаа”-ны гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээнд өөрийн газар нутгийг гуравдагч этгээдэд ашиглуулахгүй, хөрш орнуудынхаа эсрэг аливаа түрэмгийлсэн үйл ажиллагаанд оролцохгүй гэж заасан. Энэ нь хөрш хоёр улстайгаа байгуулсан гэрээний дагуу хоёр хөрштэйгээ сайн харилцаатай өдгөөг хүрлээ. Энэ үеэс авахуулаад хоёр хөрш оронтойгоо тэнцүү харилцах зарчмыг тунхагласан. Энэхүү гэрээг манай улс чанд баримталж байгаа учраас Монгол Улс-ОХУ, Монгол Улс-БНХАУ-ын харилцаанд ойрын 10 жилд өөрчлөлт орохгүй гэж бид үздэг бөгөөд энэ талаар судалгааны ажлыг хийж байна.

2016 онд “Нэг бүс, нэг зам” төслийн хүрээнд тус хүрээлэнгийн эрдэмтэд англи, орос, хятад, япон, солонгос гэсэн таван хэл дээр эрдэм шинжилгээний товхимол хэвлүүлэн гаргаж, өдгөө төрийн болон гадаад дотоодын олон улсын харилцааны чиглэлээр судалгааг хийдэг эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиуд, эрдэмтэн судлаачдын

хүртгээл болгосон.

Даяарчлал нь 1990 оноос хойш дэлхийд дахинд эрчимтэй өрнөсөн. Мөн ижил хугацаанд “Хүйтэн дайн” дуусаж, тоталитар дэглэмийн тогтолцоо дууссан. Үүнтэй холбогдуулан Гадаад хэргийн яам, Намын төв хороо зэрэг уламжлалт гадаад бодлогын шийдвэр гаргадаг үе мөн адил дууссан. Ингэснээр Монгол Улсын шинэ “Үндсэн хууль” батлагдаж, ардчилсан хүмүүнлэг нийгэм байгуулах зорилт тавигдсан. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь хуучин уламжлалт босоо хэлбэрээр явуулдаг журам өөрчлөгдөж, УИХ, улс төрийн нам, олон нийтийн оролцоотойгоор хэвтээ хэлбэрээр шийдвэр гаргах нөхцөл байдалд хүрсэн.

Монгол улс чөлөөт зах зээлд шилжисэнээр уламжлалт гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц өөрчлөгдөж, УИХ, улс төрийн намууд, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагын оролцоотойгоор явагдаж, гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад шинэ тогтолцоо бий болсон. Монгол Улс нь парламентын засаглалтай, олон туйлт гадаад бодлого явуулдаг ардчилсан улс болсон. Эдийн засгийн 70 хувь нь хувийн салбарт шилжсэн. Мөн үзэл суртлын хяналт тавьдаг байсан тогтолцоо үгүй болж, хэвлэл мэдээлэл үзэл суртлын хяналтаас ангижирсан. Өөрөөр хэлбэл; Монгол Улсын улс төр, эдийн засгийн шинэчлэл нь зэрэг явагдсан бөгөөд УИХ, төрийн эрх барих дээд байгууллага, улс төрийн нам зэрэг нь мөрийн хөтөлбөрөө өөрсдөө боловсруулдаг болж, гадаад бодлогын чиглэлээ тогтоодог болсон.

2020 он хүртэл Монгол Улс 550 төрлийн тогтмол хэвлэл, сонин сэтгүүлийг хэвлэдэг болсон. 2005 он хүртэл байгууллагуудыг Хууль зүйн яам бүртгэдэг байсан бол Улсын бүртгэлийн газар бүртгэдэг болсон. Мөн олон зуун төрийн бус байгууллага байгуулагдсан. Төрийн бус байгууллага нь дотроо хоёр төрөл байна. Төрийн оролцоотойгоор болон төрийн бус оролцоотойгоор (NGO) гэсэн. Өөрөөр хэлбэл; гадаад бодлогын шийдвэр гаргалтанд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн санал харгалзан үздэг болсон.

XX зууны сүүлийн арван жилд төрийн бус байгууллага нь гадаад бодлогын шийдвэр гаргалтанд оролцох оролцоо нь нэмэгдсэн. Олон арван төрийн бус байгууллага байгуулагдаж, гадаад харилцаа болон

эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа өргөжсөн. Ингэхийн хэрээр олон нийтийн дипломат (Public Diplomacy) ажиллагаа өргөжсөн.

Хуучин төрийн тусгай алба гадаад бодлогын ажлыг дагнан явуулдаг байсан уламжлалт гадаад бодлогын чиглэл өөрчлөгдөж, УИХ, Засгийн газар, улс төрийн нам нь өөрсдийн гадаад харилцааны чиглэлд ажиллах болсон. Өөрөөр хэлбэл; гадаад бодлогын шийдвэр гаргах явцад иргэний нийгмийн оролцоо нэмэгдэх болсон. Тэдний үүрэг ролийг нэмэгдүүлэх, ямар эрхзүйн орчинд байлгах талаар төрийн тусгай алба болон УИХ нь төрийн шийдвэр гаргах үйл явцад анхааралаа хандуулах болсон. Өнөөдрийн нийгмийн тогтолцоо нь хэвлэл мэдээллийн болон хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн байна. Олон улсын байгууллага болон хэвлэлийнхэн уламжлалт гадаад бодлого боловсруулагчдтай хамтран ажиллах цаг болсон байна.

Гадаад бодлогын асуудал хамгийн ойр байгууллага бол их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагууд ордог. Энэ нь их дээд сургуульд залуу үеийг бэлтгэн сургах болон өнгөрсөн, одоо, ирээдүйд төрийн бодлогыг ойлгуулах, судлаачид өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, зарим үед тодорхой асуудлаар өөрсдийн саналыг хүргэдэг болж байна.

Монгол Улсад ардчилал эхэлсэн өнгөрсөн 26 жилийн хугацаанд хоёр ч удаа гадаад бодлогын үзэл баримтлалыг гаргаж, хоёр удаа өөрчлөн дүн шинжилгээ хийсэн. Гадаад бодлогын талаар олон арван эрдэм шинжилгээний олон улсын болон дотоодын хурлыг зохион байгуулж байна. Монгол улсад ардчилалаар дамнасан улсуудын чуулга уулзалт АСЕМ-ийн уулзалтыг амжилттай зохион байгуулсан.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, Олон Улсын Харилцааны Хүрээлэн нь 50 жилийн түүхэнд хоёр хөрштэйгээ явуулсан гадаад бодлогыг сайтар судалсан байна. Мөн эдийн засгийн харилцаа ямар түвшинд хүрсэн талаар эрдэм шинжилгээний суурь болон хавсарга судалгаанууд хийгдсэн. Тус хүрээлэн нь олон улсын харилцаа хамтын ажиллагааны бүхий л чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг хийж буй Монгол Улсын эрдэм шинжилгээний гол байгууллага бөгөөд гадаадын эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, их дээд сургуулиудтай нягт харилцаатай ажилладаг.

Олон улсын харилцааны хүрээлэн нь дараахь гадаадын байгууллагуудтай хамтран ажилладаг. Үүнд:

- ОХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын Хүрээлэн, Дорно дахины судлалын хүрээлэн
- ОХУ-ын Сибирийн ШУА-ийн Монгол-Төвд Судлалын Хүрээлэн
- ОХУ-ын Эрхүүгийн Байгалийн Улсын Их Сургууль
- БНХАУ-ын Бээжингийн Ардын Их Сургууль
- ӨМӨЗО-ны Өвөр Монголын Их Сургууль
- БНХАУ-ын Хармөрөн мужийн Нийгмийн шинжлэх ухааны Академи
- БНХАУ-ын Гирин мужийн Нийгмийн шинжлэх ухааны Академи
- Шанхайн Олон улсын Харилцааны Их Сургууль
- БНСУ-ын Инха Их Сургууль
- БНСУ-ын Дангук Их Сургууль
- Япон улсын Шиманогийн Их Сургууль
- Токио, Осака хотын Гадаад судлалын Их Сургууль
- Францын Ле Хаверийн Их Сургууль
- Нидерландын Клигандалийн Институт
- Камбожийн Олон Улсын Харилцааны Хүрээлэн
- Лаосын Олон Улсын Харилцааны Дээд Сургууль
- Казахстаны Алматын Аль-Фарабигийн нэрэмжит Үндэсний Их сургууль
- Киргизстаны Бишкекийн Их Сургууль гэх мэт олон улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг.

Бид Монгол Улсын гадаад бодлого, Монгол Улсын аюулгүй байдал, Монгол Улсын бүс нутгийн харилцаа хамтын ажиллагаа, “Нэг бүс, нэг зам” хөтөлбөрийн хүрээнд олон улсын чиглэлээр судалгаа хийж олон нийтэд таниулдаг. Мөн дотоодын болон олон улсын

хэмжээний хурлуудад идэвхитэй оролцож байгаа нь эцсийн дүнд гадаад бодлогын шийдвэр гаргах тал дээр өөрсдийн зохих хувь нэмрээ оруулж байна.

Та бүхний хуралд амжилт хүсье!

Анхаарал тавьсанд баярлалаа.
байх болно.